

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/022/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2025.02.19	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Ахлах аудитор Утас: 99061829 Ахлах аудитор Утас: 99333147 Цахим хуудас: www.audit.mn	Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn М.Алтантуяа Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Г.Энхзул Цахим хаяг: enkhzulg@audit.gov.mn
--	---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2025.02.19 № 2/17
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Олон улсын төсөл хөтөлбөрөөр Байгаль орчин аялал жуулчлалын яамны 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 08/1323 тоот албан бичгээр "Nissan Patrol GRX Y61" загварын авто машиныг байгууллагын нэр дээр Авто тээврийн бүртгэлд бүртгүүлэн 61-00 БНН улсын дугаартайгаар 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс байгаа боловч бүртгэлд тайланд тусгаагүй байна. Байгаль орчин, уур

5020174

амьсгалын өөрчлөлтийн яамнаас 2025.02.12-ны 09/716 тоот албан бичгээр “Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас манай 2024 оны 12 сард хөрөнгө бүртгүүлэх тухай хүсэлт хүргүүлснийг буцаасан” гэсэн тайлбарыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт өгсөн боловч холбогдох нотлох баримтыг ирүүлээгүй болно

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт, 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 96.2 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	369,478,664.68	429,903,545.44
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	20,000.00	20,000.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	20,000.00	20,000.00
3121	Төгрөг	20,000.00	20,000.00
31211	Төрийн сангийн харилцах	20,000.00	20,000.00
33	АВЛАГА	-	411,807.28
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	411,807.28
35	БАРАА МАТЕРИАЛ	369,458,664.68	429,471,738.16
351	Түүхий эд материал	340,043,794.73	379,326,368.21
35110	Тусгай зориулалттай материал	340,043,794.73	379,326,368.21
354	Хангамжийн материал	29,414,869.95	50,145,369.95
35410	Бичиг хэргийн материал	1,002,336.41	906,336.41
35420	Аж ахуйн материал	18,281,404.06	46,417,904.06
35440	Түлш, шатах тослох материал	-	240,000.00
35470	Бусад хангамжийн материал	10,131,129.48	2,581,129.48
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	966,527,533.87	1,271,334,871.23
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	966,527,533.87	1,271,334,871.23
392	Биет хөрөнгө	740,156,367.15	1,043,684,537.79
39201	Барилга, байгууламж, орон сууц	657,061,103.66	676,861,103.66
39202	Хуримтлагдсан элэгдэл	(64,524,548.26)	(77,508,820.42)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	83,608,973.78	84,588,723.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	(46,567,716.48)	(56,690,583.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	255,042,286.55	610,642,116.61
39206	Хуримтлагдсан элэгдэл	(148,383,890.08)	(198,113,441.55)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,507,750.00	17,567,750.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,587,592.02)	(13,662,311.29)
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,280,000.00	6,280,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,280,000.00)	(6,280,000.00)
393	Биет бус хөрөнгө	226,371,166.72	227,650,333.44
39301	Программ хангамж	1,546,219.00	3,046,219.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,317,052.28)	(1,537,885.56)
39303	Бусад биет бус хөрөнгө	226,142,000.00	226,142,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН Ш=I+II	1,336,006,198.55	1,701,238,416.67
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	9,766,621.76
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	9,766,621.76
413	Өглөг	-	9,766,621.76
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	9,766,621.76
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,336,006,198.55	1,691,471,794.91
51	Засгийн газрын хувь оролцоо	1,336,006,198.55	1,691,471,794.91
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	587,740,743.91	587,740,743.91

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51106	Эздийн өмчийн бусад хэсэг	587,740,743.91	587,740,743.91
512	Хуримтлагдсан үр дүн	419,395,871.79	774,861,468.15
51210	Өмнөх үеийн үр дүн	419,395,871.79	419,395,871.79
51220	Тайлант үеийн үр дүн	-	355,465,596.36
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	328,869,582.85	328,869,582.85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,336,006,198.55	1,701,238,416.67

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,114,296,420.62	3,564,675,573.06
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	124,522,420.62	299,113,097.06
120	Нийтлэг татварын бус орлого	124,522,420.62	299,113,097.06
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	124,522,420.62	299,113,097.06
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	200,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	124,322,420.62	298,913,097.06
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,989,754,000.00	3,265,562,476.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,988,296,200.00	3,198,753,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,988,296,200.00	3,198,753,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,457,800.00	66,809,376.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	64,292,376.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,457,800.00	2,517,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,002,560,147.49	3,209,108,625.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,002,560,147.49	3,209,108,625.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,925,575,033.10	3,137,185,121.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,623,444,592.31	2,606,360,402.31
210101	Үндсэн цалин	1,020,775,879.30	1,555,590,712.15
210102	Нэмэгдэл	327,672,947.66	779,195,740.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	148,200,000.00	194,029,000.00
210104	Урамшуулал	126,795,765.35	77,544,950.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	204,459,253.79	349,454,400.47
210201	Тэтгэврийн даатгал	142,363,064.04	234,046,556.02
210202	Тэтгэмжийн даатгал	16,267,300.00	26,439,652.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,013,800.00	25,995,094.22
210204	Ажилгүйдлийн даатгал	3,109,122.05	12,594,619.84
210205	Эрүүл мэндийн даатгал	29,705,967.70	50,378,477.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,670,200.00	52,899,668.00
210301	Гэрэл, цахилгаан	5,921,700.00	7,602,328.00
210302	Түлш, халаалт	39,388,500.00	44,556,340.00

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	360,000.00	741,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,699,582.60	40,490,411.92
210401	Бичиг хэрэг	1,622,000.00	1,663,000.00
210402	Тээвэр, шатахуун	9,019,100.00	10,425,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,761,230.00	5,224,958.40
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,089,400.00	17,700,538.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	375,000.00	-
210408	Бараа материал акталсны зардал	5,832,852.60	5,476,015.52
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	220,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	220,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,896,000.00	3,144,000.00
210702	Дотоод албан томилолт	1,896,000.00	3,144,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,914,930.00	9,266,296.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,687,570.00	7,151,986.00
210803	Даатгалын үйлчилгээ		277,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	435,592.00	305,335.40
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	10,000.00
210807	Газрын төлбөр	1,406,768.00	1,521,475.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	308,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,490,474.40	75,349,942.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,267,476.00	217,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хөрогдол	17,222,998.40	75,132,242.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,985,114.39	71,923,503.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	75,054,200.00	70,924,017.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		53,200,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	75,054,200.00	17,724,017.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,930,914.39	999,486.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,930,914.39	999,486.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	111,736,273.13	355,566,947.36
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	111,736,273.13	355,566,947.36

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,989,974,000.00	3,265,762,476.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	220,000.00	200,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	220,000.00	200,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	200,000.00	200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	200,000.00
120009	Бусад орлого	20,000.00	

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,989,754,000.00	3,265,562,476.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,988,296,200.00	3,198,753,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,988,296,200.00	3,198,753,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,457,800.00	66,809,376.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	64,292,376.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,457,800.00	2,517,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,984,104,000.00	3,118,471,015.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,984,104,000.00	3,118,471,015.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,907,118,885.61	3,046,547,511.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,623,573,871.82	2,618,908,788.30
210101	Үндсэн цалин	1,017,935,100.00	1,371,479,389.45
210102	Нэмэгдэл	323,225,371.82	766,852,899.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	148,200,000.00	312,875,749.83
210104	Урамшуулал	134,213,400.00	167,700,750.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	204,459,253.79	327,551,200.00
210201	Тэтгэврийн даатгал	141,273,200.00	222,794,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	16,267,300.00	26,189,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,013,800.00	13,094,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,253,600.00	13,094,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	30,651,353.79	52,378,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,060,200.00	45,589,668.00
210301	Гэрэл, цахилгаан	5,921,700.00	7,602,328.00
210302	Түлш, халаалт	43,778,500.00	37,246,340.00
210303	Цэвэр, бохир ус	360,000.00	741,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,986,700.00	10,997,858.40
210401	Бичиг хэрэг	1,479,000.00	589,000.00
210402	Тээвэр, шатахуун	9,019,100.00	4,971,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,874,200.00	5,224,958.40
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	614,400.00	212,000.00
2105	Нормативт зардал	191,300.00	187,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	191,300.00	187,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,109,900.00	8,620,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	259,900.00	220,000.00
210604	Урсгал засвар	3,850,000.00	8,400,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,896,000.00	3,144,000.00
210702	Дотоод албан томилолт	1,896,000.00	3,144,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,841,660.00	31,548,296.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,614,300.00	29,433,986.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	277,500.00

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	435,592.00	305,335.40
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	10,000.00
210807	Газрын төлбөр	1,406,768.00	1,521,475.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	308,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,985,114.39	71,923,503.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	75,054,200.00	70,924,017.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	53,200,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	75,054,200.00	17,724,017.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,930,914.39	999,486.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,930,914.39	999,486.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,870,000.00	147,291,461.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,850,000.00	147,190,110.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,850,000.00	147,190,110.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,850,000.00	147,190,110.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,850,000.00	147,190,110.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(5,850,000.00)	(147,190,110.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	20,000.00	101,351.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,000.00	20,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20,000.00	20,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/	
					Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00		0.00
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	587,740,743.91	328,869,582.85	419,395,871.79	0.00	1,336,006,198.55
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	587,740,743.91	328,869,582.85	419,395,871.79	0.00	1,336,006,198.55
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	587,740,743.91	328,869,582.85	419,395,871.79	0.00	1,336,006,198.55
D08	Тайлант үеийн үр дүн			355,465,596.36		355,465,596.36
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	587,740,743.91	328,869,582.85	774,861,468.15	0.00	1,691,471,794.91

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,198,953,100.00	3,197,953,613.10	999,486.90	99.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,198,953,100.00	3,197,953,613.10	999,486.90	99.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,180,765,300.00	3,180,229,596.10	535,703.90	99.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,618,908,800.00	2,618,908,788.30	11.70	100.00
210101	Үндсэн цалин	1,371,479,400.00	1,371,479,389.45	10.55	100.00
210102	Нэмэгдэл	766,852,900.00	766,852,899.02	0.98	100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	320,492,700.00	312,875,749.83	7,616,950.17	97.62
210104	Урамшуулал	160,083,800.00	167,700,750.00	(7,616,950.00)	104.76
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	327,551,200.00	327,551,200.00	-	
210201	Тэтгэврийн даатгал	222,794,800.00	222,794,800.00	-	
210202	Тэтгэмжийн даатгал	26,189,100.00	26,189,100.00	-	
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,094,500.00	13,094,500.00	-	
210204	Ажилгүйдлийн даатгал	13,094,600.00	13,094,600.00	-	
210205	Эрүүл мэндийн даатгал	52,378,200.00	52,378,200.00	-	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,591,000.00	45,589,668.00	1,332.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	7,450,000.00	7,602,328.00	(152,328.00)	102.04
210302	Түлш, халаалт	37,400,000.00	37,246,340.00	153,660.00	99.59
210303	Цэвэр, бохир ус	741,000.00	741,000.00	-	
2104	Хангамж, бараа материалын зардал	11,024,300.00	10,997,858.40	26,441.60	99.76
210401	Бичиг хэрэг	596,400.00	589,000.00	7,400.00	98.76
210402	Тээвэр, шатахуун	4,971,900.00	4,971,900.00	-	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,244,000.00	5,224,958.40	19,041.60	99.64
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	212,000.00	212,000.00	-	
2105	Нормативт зардал	187,700.00	187,700.00	-	
210503	Нормын хувцаас, зөөлөн эдлэл	187,700.00	187,700.00	-	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	126,115,800.00	126,070,210.00	45,590.00	99.96
210601	Багаж, техник, хэрэгсэл	126,115,800.00	126,070,210.00	45,590.00	99.96
2107	Томиллолт, зочны зардал	3,170,700.00	3,144,000.00	26,700.00	99.16

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	3,170,700.00	3,144,000.00	26,700.00	99.16
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,215,800.00	47,780,171.40	435,628.60	99.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	45,796,400.00	45,665,861.00	130,539.00	99.71
210803	Даатгалын үйлчилгээ	304,000.00	277,500.00	26,500.00	91.28
210804	Тээврийн хэрэгслийн татвар	305,400.00	305,335.40	64.60	99.98
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	10,000.00	10,000.00	-	
210807	Газрын төлбөр	1,800,000.00	1,521,475.00	278,525.00	84.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,187,800.00	17,724,017.00	463,783.00	97.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,187,800.00	17,724,017.00	463,783.00	97.45
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,187,800.00	17,724,017.00	463,783.00	97.45
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,198,953,100.00	3,198,953,613.10	999,486.90	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,198,753,100.00	3,198,953,613.10	999,486.90	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,198,753,100.00	3,198,953,613.10	999,486.90	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	200,000.00	200,000.00	-	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	200,000.00	-	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	20,000.00	(20,000.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	20,000.00	(20,000.00)	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	94.00	94.00	-	
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	87.00	87.00	-	
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	-	

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,457,800.00	66,708,025.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,457,800.00	66,708,025.00

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,457,800.00	13,508,025.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	8,400,000.00
210604	Урсгал засвар	-	8,400,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,457,800.00	5,108,025.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,457,800.00	5,108,025.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	53,200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	53,200,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	53,200,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	101,351.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		101,351.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,457,800.00	66,809,376.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,457,800.00	66,809,376.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	64,292,376.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,457,800.00	2,517,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв нь цаг агаарын хувирал өөрчлөлтийг тасралтгүй ажиглан ус цаг уур, орчны мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хангах, нийгэм эдийн засаг байгалийн болзошгүй аюулаас гарз хохиролгүй гаргах сэрэмжлүүлэх мэдээ боловсруулах үйл ажиллагаа явуулдаг байна.

Байгууллагын эрхэм зорилгоо "Аймаг орон нутгийн уур амьсгал түүний хувьсан өөрчлөгдөх зүй тогтол орчны бохирдолд байнгын хяналт шинжилгээ хийх, усны нөөц, цаг агаарын төлөв байдлыг урьдчилан тодорхойлох /прогнозлох/ шинжлэх ухаан техник технологийн дэвшилд тулгуурласан, мэргэжлийн инженер техникчтэйгээр орон тоогоо нэмэгдүүлсэн ус, цаг уур орчны шинжилгээний төвүүдийн түвшинд хүрэх, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх" гэж тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Цаг уур орчны шинжилгээний газрын 2024 оны А/363 дугаар тушаалаар баталсан " Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Цаг уур орчны шинжилгээний төв нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1. Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө: 4.1.3-

д "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 365,232.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	
				ДҮН	ЭЗЛЭХ ХУВЬ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	369,478.70	429,903.50	60,424.80	116.35
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	20.00	20.00	0.00	100.00
33	АВЛАГА	0	411.80	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	369,458.70	429,471.70	60,013.00	116.24
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	966,527.50	1,271,334.90	304,807.40	131.54
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	966,527.50	1,271,334.90	304,807.40	131.54
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,336,006.20	1,701,238.40	365,232.20	127.34
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	9,766.60	0.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	9,766.60	9,766.60	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,336,006.20	1,691,471.80	355,465.60	126.61
51	Засгийн газрын хувь оролцоо	1,336,006.20	1,691,471.80	355,465.60	126.61
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,336,006.20	1,701,238.40	365,232.20	127.34

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 20.0 мянган төгрөг байгаа нь ахмадын сангийн үлдэгдэл байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 429,471.7 мянган төгрөг болж өмнөх оноос 60,013.1 мянган төгрөгөөр өссөн байна. Төсвийн худалдан авалтаар 72,321.6 мянган төгрөгийн бараа материал, 62,163.6 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авсан байна.

Авлага дансны үлдэгдэл 411.8 мянган төгрөг нь ажилчдаас авах авлага байна. Өглөг дансны эцсийн үлдэгдэл 9,766.6 мянган төгрөг нь 2024 оны 04 дүгээр сарын 01-нээс Засгийн газрын 128 дугаар тогтоолоор ажилчдын цалинг нэмэгдүүлэн тогтоож олгосон боловч цалингийн санд нэмэгдэл орж ирээгүй өр авлага үүсэж, 2024 оны 09 болон 10 дугаар сард цалингийн санг нэмэгдүүлсэн боловч төсөв хүрэлцэхгүй ХХОАТ-ын өр үүссэн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,271,334.9 мянган төгрөг болж 304,807.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн худалдан авалтаар 294,380.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, Цаг уур орчны шинжилгээний газраас 46,032.1 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэж, Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас 127,899.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 979.8 мянган төгрөгийн мотоцикл, нийт 126,533.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө шилүүлэн авсан нь бараа материалын данс өсөхөд голлох нөлөө үзүүлжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,691,471.8 мянган төгрөг болж мянган төгрөг болж 355,465.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн хуримтлагдсан үр дүн 355,229.4 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,516,361.1 мянган төгрөгөөр тооцон зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалингийн сан нэмэгдсэнтэй холбоотой төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,749.4 мянган төгрөгөөр нэмж 3,265,762.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 3,198,953.1 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 3,197,953.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	3,175,590.90	3,175,055.20	(535.70)	99.98
2	80220 Холбооны суваг ашигласны хөлс	5,174.40	5,174.40	-	100
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	18,187.80	17,724.00	(463.80)	97.45
Нийт		3,198,953.10	3,197,953.60	(999.50)	99.14

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар давсан орлого 66,809.4 мянган төгрөг орсноос 47,880.0 мянган төгрөгийг нэг удаагийн тусламж, 7,837.9 мянган төгрөгийг бичиг хэрэг, бараа материалын зардалд, 9,536.1 мянган төгрөгийг хяналт, засварын зардалд зарцуулж, үлдэгдэл 101.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд түлш халаалтын зардалд 37,246.3 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардалд 7,602.3 мянган төгрөг, цэвэр бохир усны зардалд 741.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тус байгууллага нь “Скейл” ХХК-тай түлш нийлүүлэх гэрээ, Баянхонгор Эко дулаан ХХК-тай дулаанаар хангах гэрээ, нүүрс нийлүүлэх гэрээ, “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-тай цахилгаанаар хангах гэрээ, Техно Кон ХХК, Ай Ти Зон ХХК-тай тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээ тус тус байгуулж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхзул гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дугаар сарын 16-ний өдрийн 16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 3,198,900.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 31,989.0 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 20,792.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй бөгөөд тогтмол зардлыг 100 хувь зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 3,251,046.5 мянган төгрөгийн санхүүжилт, 213,824.2 мянган төгрөгийн 15 зарлагын гүйлгээг бүрэн мэдээлсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж аудитаар 207,384.90 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 80 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	207,384.9	1	207,384.9	100%
Нийт дүн	1	207,384.9	1	207,384.9	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгаль орчин аялал жуулчлалын яамны 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 08/1323 тоот албан бичгээр автомашин хүлээн авсан байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын хөрөнгө орлогоор бүртгэж авах тушаал гараагүйтэй холбоотой автомашиныг орлогоор бүртгэж аваагүй байна.

Иймд дараагийн аудитаар уг асуудлыг анхаарч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 9,388.2 мянган төгрөгийн 1 зөрчил илэрч зөвлөмж хүргүүлж байна.

Зөвлөмж

- Тайлант онд Засгийн газрын 128 дугаар тогтоолоор 2024 оны 04 дүгээр сарын 01-нээс албан хаагчдын цалин нэмсэнтэй холбоотойгоор батлагдсан төсвийг

нэмэгдүүлэн тодотгосон боловч тооцооллын алдаанаас төсөв хүрээгүйгээс шалтгаалж 9,388.2 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид төсвийн төслийг төлөвлөхдөө үндэслэлтэй төлөвлөж, батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаа явуулах, өглөгийн барагдуулах зөвлөмжийг хүргүүлж байна.

Аудитаар илэрсэн зөрчил нь урьдчилан тооцсон материаллаг байдлаас бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд 9,388.2 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг үүссэн байна.	1	9,388.2					1	9,388.2
Дүн	1	9,388.2					1	9,388.2

-----oO-----